



БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Баянхонгор аймгийн Сум дундын ойн анги 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БНА-2019/106/СТА-ТШЗ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)

(Хотын нэр оруулах)

2019 он

Тэргүүлэх аудитор: .....

Утас: ..... Цахим хаяг: .....

Аудитын менежер: .....

Утас: ..... Цахим хаяг: .....

Аудитор: .....

Утас: ..... Цахим хаяг: .....

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

## Агуулга

1	Аудитын гэрчилгээ	3
2	Аудитын тайлан	5
2.1	Оршил.....	5
2.2	Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага .....	5
2.3	Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт .....	6
2.4	Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин.....	6
2.5	Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ.....	7
2.6	Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал.....	8
2.7	Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар.....	8
2.8	Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	8
2.8.1	Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал..... <b>Error! Bookmark not defined.</b>	
2.9	Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал.....	9
2.10	Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга .....	9
2.11	Шилэн дансны мэдээлэл .....	9
2.12	Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга .....	9
2.13	Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл .....	9
3	Менежментийн захидал <b>Error! Bookmark not defined.</b>	
4	Аудит хийсэн санхүүгийн тайлан	10

## 1 Аудитын гэрчилгээ

БАЯНХОНГОР АЙМГИЙН СУМ  
ДУНДЫН ОЙН АНГИЙН ДАРГА  
Н.БАЯРСАЙХАН ТАНАА

### Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Баянхонгор аймгийн Сум дундын ойн ангийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

### Зөрчилгүй санал дүгнэлт

Баянхонгор аймгийн Сум дундын ойн ангийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

### Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Баянхонгор аймгийн Сум дундын ойн ангийн 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын

хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

### **Үүрэг хариуцлага**

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудитын хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.МӨНХБАТ

## 2 Аудитын тайлан

### 2.1. Оршил

Баянхонгор аймгийн Сум дундын ойн ангийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Баянхонгор аймгийн Сум дундын ойн ангийн дарга Н.Баярсайханд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

### 2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянхонгор аймгийн Сум дундын ойн ангийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянхонгор аймгийн Сум дундын ойн ангийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019.01.31-нээс 2019.02.01-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019.02.21-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газрын Гэрээт аудитор Ж.Чогсомжанлав хариуцаж хэрэгжүүлэв.

Баянхонгор аймгийн Сум дундын ой ангийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газарт 2019.01.25-ны өдрийн 01 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

### **2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

### **2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Баянхонгор аймгийн Сум дундын ой ангийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Баянхонгор аймгийн Сум дундын ой анги нь Сум дундын болон сум дүүргийн ой анги орон нутгийн төсөвт үйлдвэрийн газар /цаашид ОНТҮГ гэх/ нь Монгол улсын “Иргэний тухай”, “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай”, “Төсвийн тухай”, “Хөдөлмөрийн тухай”, “Ойн тухай” хууль болон бусад холбогдох хууль тогтоомж болон Ойн анги нь Ойн тухай хуулийн 18,3 дугаарт заасан эрх үүргийн хүрээнд ойн баялгийн нөөцийг хамгаалах, тогтвортой ашиглах, нөхөн сэргээх, үржүүлэх нь бидний зорилго юм. гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Үйл ажиллагааны чиглэл:

Баянхонгор аймгийн Сум дундын ой ангийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Ойг хамгаалах гэж ой, хээрийн түймэр болон хөнөөлт шавж, өвчин зэрэг ойн төлөв байдлыг доройтуулах хүчин зүйлээс урьдчилан сэргийлэх, ойн

баялгийг жам ёсоороо нөхөн сэргэх боломжийг алдагдуулахгүйгээр ойн нөөцийн даацад тохируулан зохистой ашиглах, нөхөн сэргээх, тэдгээрт хяналт тавьж гарсан зөрчлийг таслан зогсоох үйл ажиллагаа.

- Ойн нөөцийн төлөв байдал, чанарыг тодорхойлох, үнэлгээ өгөх, нөөцийн өөрчлөлт, ашиглалт, хамгаалалтын байдлыг хянах, ой, хээрийг түймэр, хөнөөлт шавжийн тархалт, ойн нөөцийн хомсдол, газрын доройтол, бохирдлоос урьдчилан сэргийлэх, хамгаалах, ойн ашиглалттай холбоотой гарсан зөрчлийг таслан зогсоох үйл ажиллагааг төлөвлөн зохион байгуулах.

Баянхонгор аймгийн Сум дундын ойн ангийн үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Баянхонгор аймгийн Сум дундын ойн ангийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

## **2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцсэн байна.

Баянхонгор аймгийн Сум дундын ойн ангийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн түвэгтэй байдлыг үнэлэхэд 45 буюу мэдээлэл

технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Баянхонгор аймгийн Сум дундын ойн ангийн санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “ACOLOUS” программ хангамж ашигладаг байна.

Баянхонгор аймгийн Сум дундын ойн ангийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд **Дунд** гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт **Үр нөлөөгүй** гэж үзлээ.

## **2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитын явцад Баянхонгор аймгийн Сум дундын ойн ангийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн **7** эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 7 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

## **2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд Баянхонгор аймгийн Сум дундын ойн ангийн 2018 оны санхүүгийн тайланд аудит хийж санал дүгнэлт гаргахад шаардлагатай материаллаг байдлын түвшинг урьчилсан байдлаар тооцохдоо суурь үзүүлэлтийг үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүнг сонгох нь зохимтой гэж үзлээ.

Баянхонгор аймгийн Сум дундын ойн ангийн **2018** оны **Нийт зардал** 50108.14 мянган төгрөг бөгөөд сонгосон суурь үзүүлэлтийн **2** хувиар тооцож, материаллаг байдлын түвшнийг урьдчилсан байдлаар 1002.16 мянган төгрөгөөр тогтоож, Маягт № Б201-ээр баримтжуулан баталгаажуулав.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

## **2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 5 чиглэлээр аудитын 7 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 2 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 5 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна 2 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

## **2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

### **Байхгүй**

#### **2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Баянхонгор аймгийн Сум дундын ойн ангийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой 2018 онд 46518.8 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 3.5-д дэлгэрэнгүй харуулав.

Төсвийн зардлын нийт гүйцэтгэл 40870.0 мянган төгрөг буюу 87.9 хувьтай байна.

#### **2.11. Шилэн дансны мэдээлэл**

Баянхонгор аймгийн Сум дундын ойн ангийн Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллага нь Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газраас хийсэн “Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэнд хийсэн аудит”-таар Шилэн дансны хуулийн 6.1-д заасан мэдээллийн өөрт хамаарах 25 мэдээллийг хугацаанд нь ,6.4-д заасан мэдээллээс өөрт хамаарах 5,0 сая төгрөгөөс үнийн дүн бүхий орлогын гүйлгээ гараагүй байна.

#### **2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга**

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 100 хувьтай байна.

Эдгээр зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

#### **2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Баянхонгор аймгийн Сум дундын ойн ангийн 2018 оны санхүүгийн тайлан,

төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

**Баянхонгор аймгийн Сум дундын ой ангийн 2018** оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

### 3 Аудит хийсэн санхүүгийн тайлан

#### 3.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>21,782,855.00</u></b>	<b><u>35,591,715.90</u></b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	00.00	162,360.90
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	00.00	162,360.90
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	21,782,855.00	35,429,355.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	21,782,855.00	35,429,355.00
35410	Бичиг хэргийн материал	9,500.00	00.00
35420	Аж ахуйн материал	6,894,355.00	6,894,355.00
35470	Бусад хангамжийн материал	14,879,000.00	28,535,000.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>107,942,382.55</u></b>	<b><u>178,496,649.17</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	107,942,382.55	178,496,649.17
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	107,785,632.68	106,313,599.32
39201	Барилга, байгууламж, орон сууц	6,260,000.00	6,179,800.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-1,163,916.73	00.00
39203	Авто-тээврийн хэрэгсэл	26,398,400.00	26,398,400.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-21,118,719.76	-25,401,919.88
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	15,074,278.00	11,082,453.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-15,482,024.55	-11,582,849.51
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	1,023,459.00	1,023,459.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-845,843.28	-919,243.29
39214	Бусад үндсэн хөрөнгө	97,640,000.00	99,533,500.00
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	156,749.87	72,183,049.85
39301	Програм хангамж	836,000.00	836,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-679,250.13	-783,750.15
39303	Бусад биет бус хөрөнгө	00.00	72,130,800.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>129,725,237.55</u></b>	<b><u>214,088,365.07</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b><u>71,175.00</u></b>	<b><u>76,000.00</u></b>
<b>41</b>	<b>БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР</b>	71,175.00	76,000.00
<b>413</b>	<b>Өглөг</b>	71,175.00	76,000.00
<b>4136</b>	<b>Бусад өглөг</b>	175.00	00.00
41361	Байгууллагад төлөх өглөг	175.00	00.00

Баянхонгор аймгийн Сум дундын ой ангийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b>129,654,062.55</b>	<b>214,012,365.07</b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	129,654,062.55	214,012,365.07
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	139,258,086.00	211,388,886.00
51101	Өмч: - төрийн	139,258,086.00	211,388,886.00
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	<b>-9,604,023.45</b>	<b>1,011,679.07</b>
51210	Өмнөх үеийн үр дүн	-9,604,023.45	-9,604,023.45
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	10,615,702.52
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	00.00	1,611,800.00
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b>129,725,237.55</b>	<b>214,088,365.07</b>

**3.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>29,656,700.00</b>	<b>60,723,840.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>00.00</b>	<b>1,794,900.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	00.00	1,794,900.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	00.00	1,794,900.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	90,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	00.00	1,704,900.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>29,656,700.00</b>	<b>58,928,940.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	4,000,000.00	13,125,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,000,000.00	13,125,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	25,286,100.00	44,018,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	25,286,100.00	44,018,800.00
<b>1330</b>	<b>Төсвийн захирагчдаас</b>	370,600.00	00.00
133003	Хөрөнгийн	370,600.00	00.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	00.00	1,785,140.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	00.00	1,785,140.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>28,816,461.28</b>	<b>49,878,320.89</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>28,816,461.28</b>	<b>49,788,320.89</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	28,816,461.28	44,764,278.89
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	16,857,048.00	31,909,643.00
210101	Үндсэн цалин	16,857,048.00	30,269,102.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	1,640,541.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	2,330,390.24	4,178,388.00
210201	Тэтгэврийн даатгал	1,906,127.42	3,740,445.00
210202	Тэтгэмжийн даатгал	-103,879.84	87,588.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	157,694.51	109,485.00
210204	Ажилгүйдлийн даатгал	33,710.97	21,897.00
210205	Эрүүл мэндийн даатгал	336,737.18	218,973.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	51,279.00	208,211.00
210301	Гэрэл, цахилгаан	51,279.00	208,211.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	2,328,558.00	2,415,656.00

Баянхонгор аймгийн Сум дундын ой ангийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210401	Бичиг хэрэг	166,300.00	780,900.00
210402	Тээвэр, шатахуун	2,080,000.00	1,500,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	82,258.00	134,756.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	131,000.00	481,025.00
210604	Урсгал засвар	131,000.00	481,025.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	461,500.00	573,500.00
210702	Дотоод албан томилолт	461,500.00	573,500.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	3,034,950.00	334,439.10
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,548,450.00	-162,360.90
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	99,000.00	100,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	304,000.00	304,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	63,500.00	92,800.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	20,000.00	00.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	3,621,736.04	4,663,416.79
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	3,621,736.04	4,663,416.79
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	00.00	5,024,042.00
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	00.00	1,785,140.00
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	00.00	1,785,140.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	00.00	3,238,902.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	3,238,902.00
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b>00.00</b>	<b>90,000.00</b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	00.00	90,000.00
223001	Бусад хөрөнгө	00.00	90,000.00
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b>840,238.72</b>	<b>10,845,519.11</b>
<b>225</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН</b>	00.00	229,816.59
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал	00.00	229,816.59
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	00.00	-229,816.59
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b>840,238.72</b>	<b>10,615,702.52</b>

**3.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ</b>		
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>42,350,100.00</b>	<b>59,018,940.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>00.00</b>	<b>90,000.00</b>
<b>120</b>	<b>Нийтлэг татварын бус орлого</b>	00.00	90,000.00
120004	<b>Төсөв байгууллагын өөрийн орлого</b>	00.00	90,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	00.00	90,000.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>40,054,100.00</b>	<b>58,928,940.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	10,000,000.00	13,125,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	10,000,000.00	13,125,000.00
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	30,054,100.00	44,018,800.00

Баянхонгор аймгийн Сум дундын ой ангийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	30,054,100.00	44,018,800.00
<b>1340</b>	<b>Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих</b>	00.00	1,785,140.00
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	00.00	1,785,140.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>42,350,100.00</b>	<b>59,018,940.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>42,350,100.00</b>	<b>59,018,940.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>40,675,741.00</b>	<b>53,994,898.00</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	22,353,177.00	32,123,297.00
210101	Үндсэн цалин	22,353,177.00	30,447,232.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	1,676,065.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	3,184,749.00	3,964,734.00
210201	Тэтгэврийн даатгал	2,290,767.74	3,526,791.00
210202	Тэтгэмжийн даатгал	178,913.26	87,588.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	223,706.13	109,485.00
210204	Ажилгүйдлийн даатгал	44,702.19	21,897.00
210205	Эрүүл мэндийн даатгал	446,659.68	218,973.00
<b>2103</b>	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	208,148.00	208,211.00
210301	Гэрэл, цахилгаан	208,148.00	208,211.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	2,493,717.00	2,401,156.00
210401	Бичиг хэрэг	292,300.00	766,400.00
210402	Тээвэр, шатахуун	2,080,000.00	1,500,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	121,417.00	134,756.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	799,000.00	741,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	799,000.00	741,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	361,000.00	361,200.00
210604	Урсгал засвар	361,000.00	361,200.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	657,500.00	573,500.00
210702	Дотоод албан томилолт	657,500.00	573,500.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	10,618,450.00	13,621,800.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	10,131,950.00	13,125,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	99,000.00	100,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	304,000.00	304,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	63,500.00	92,800.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	20,000.00	00.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>1,674,359.00</b>	<b>5,024,042.00</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	600,000.00	1,785,140.00
213203	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	00.00	1,785,140.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	600,000.00	00.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	1,074,309.00	3,238,902.00
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	1,074,309.00	3,238,902.00
<b>2135</b>	<b>Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	50.00	00.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	50.00	00.00

### 3.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
D01	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	139,258,086.00	00.00	-9,604,023.45	00.00	129,654,062.55
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	139,258,086.00	00.00	-9,604,023.45	00.00	129,654,062.55
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	1,611,800.00	00.00	00.00	1,611,800.00
D08	Тайлант үеийн үр дүн	72,130,800.00	00.00	10,615,702.52	00.00	82,746,502.52
D09	2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	211,388,886.00	1,611,800.00	1,011,679.07	00.00	214,012,365.07

### 3.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	32,554,100.00	31,275,791.00	46,518,800.00	40,869,898.00
21	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	32,554,100.00	31,275,791.00	46,518,800.00	40,869,898.00
210	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	31,654,100.00	30,675,791.00	46,518,800.00	40,869,898.00
2101	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	22,945,200.00	22,353,177.00	36,666,500.00	32,123,297.00
210101	Үндсэн цалин	22,945,200.00	22,353,177.00	34,686,500.00	30,447,232.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	00.00	00.00	1,980,000.00	1,676,065.00
2102	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	3,221,700.00	3,184,749.00	4,400,000.00	3,964,734.00
210201	Тэтгэврийн даатгал	2,314,100.00	2,290,767.74	2,976,100.00	3,526,791.00
210202	Тэтгэмжийн даатгал	181,500.00	178,913.26	356,000.00	87,588.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	226,900.00	223,706.13	284,800.00	109,485.00
210204	Ажилгүйдлийн даатгал	45,400.00	44,702.19	71,200.00	21,897.00
210205	Эрүүл мэндийн даатгал	453,800.00	446,659.68	711,900.00	218,973.00
2103	<b>Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал</b>	432,600.00	208,148.00	507,200.00	208,211.00
210301	Гэрэл, цахилгаан	432,600.00	208,148.00	507,200.00	208,211.00
2104	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	2,510,900.00	2,493,717.00	2,510,900.00	2,401,156.00
210401	Бичиг хэрэг	292,400.00	292,300.00	874,900.00	766,400.00
210402	Тээвэр, шатахуун	2,082,500.00	2,080,000.00	1,500,000.00	1,500,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	136,000.00	121,417.00	136,000.00	134,756.00
2105	<b>Нормативт зардал</b>	800,000.00	799,000.00	741,000.00	741,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	800,000.00	799,000.00	741,000.00	741,000.00
2106	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	361,200.00	361,000.00	361,200.00	361,200.00
210604	Урсгал засвар	361,200.00	361,200.00	361,200.00	361,200.00
2107	<b>Томиллолт, зочны зардал</b>	687,500.00	657,500.00	732,000.00	573,500.00
210702	Дотоод албан томиллолт	687,500.00	657,500.00	732,000.00	573,500.00
2108	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	695,000.00	618,500.00	600,000.00	496,800.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	132,000.00	132,000.00	00.00	00.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	99,000.00	99,000.00	100,000.00	100,000.00

**Баянхонгор аймгийн Сум дундын ой ангийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит**

210803	Даатгалын үйлчилгээ	304,000.00	304,000.00	340,000.00	304,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	100,000.00	63,500.00	100,000.00	92,800.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	20,000.00	20,000.00	20,000.00	00.00
210807	Газрын төлбөр	40,000.00	00.00	40,000.00	00.00
	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	32,554,100.00	31,275,791.00	46,518,800.00	40,869,898.00
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	30,054,100.00	28,979,791.00	44,018,800.00	40,779,898.00
132001	Орон нутгийн төсвөөс	30,054,100.00	28,979,791.00	44,018,800.00	40,779,898.00
<b>120004</b>	<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	2,500,000.00	2,296,000.00	2,500,000.00	90,000.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,500,000.00	2,296,000.00	2,500,000.00	90,000.00
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСАДЫН ТОО</b>	04.00	04.00	05.00	05.00
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	01.00	01.00
620002	Гүйцэтгэх ажилтан	03.00	03.00	00.00	00.00
620003	Үйлчлэх ажилтан	00.00	00.00	04.00	04.00

